

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	12
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХЯ	Батлан Хамгаалах Яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БХЯ-НЫ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН
АЛБА ТӨААТҮГ-ЫН ДАРГА
Э.МӨНХНАРАН ТАНАА

2020. 03.13 № 06/804
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, зорилтот түвшин, гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Э.Мөнхнаран Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шилэн дансны мэдээллийг хугацаандаа байршуулж байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, зорилтот түвшин, гүйцэтгэлд аудит хийлээ.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж, ҮАГ-ын захиалгаар Эвиденсе аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгын хамт Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 118 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Батлан хамгаалах салбарт хэрэгжүүлж буй барилга угсралт, эх засварын ажлуудад Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, барилгын норм дүрэм, стандартыг мөрдүүлж гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад оршино.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь Батлан хамгаалах салбарын хэрэгцээ, хөгжлийн чиг хандлагад нийцсэн төлөвлөлт бүхий чанартай бүтээн байгуулалтыг бий болгоход чиглэгдэнэ. Үүнд:

- Барилгын иж бүрэн зураг төсөл, төсөв боловсруулах;
- Барилгын үе шатны ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх;
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах, ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах ажлыг гүйцэтгэгч, ашиглагч, зураг төсөл боловсруулсан хуулийн этгээдүүдтэй хамтран хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллах.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын мөрдөж буй Нийгмийн даатгалын хуулинд шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг мөрдөн ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ординат ХХК-ийн “Unicus” программ хангамж ашигладаг байна.

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлсэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлт болгон 348.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 3.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцсон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 379.2 сая төгрөгийн 1 хувь буюу 3.8 сая төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 296.2 сая төгрөгөөр буюу 37 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн тооцоо, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	613.6	841.5	227.8
Авлага	23.8	18.7	(5.1)
Урьдчилж төлсөн тооцоо	67.0	146.4	79.3
Бараа материал	40.6	58.0	17.4
Үндсэн хөрөнгө	56.6	33.4	(23.1)
Биет бус хөрөнгө	0.1	-	(0.1)
Нийт хөрөнгө	801.8	1,098.0	296.2
Богино хугацаат өр төлбөр	403.2	650.0	246.8
Эздийн өмчийн дүн	398.6	448.0	49.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	801.8	1,098.0	296.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2019 онд хийгдсэн барилгын их завсрын ажлын санхүүжилт харилцах дансанд орсонтой холбоотой өссөн.

Барилга захиалагчийн албаны он дамжин хэрэгжүүлж буй их засварын ажлууд нэмэгдсэн тул урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 79.3 сая төгрөгөөр өссөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 296.2 сая төгрөгөөр өссөн нь барьцааны мөнгийг хугацааны эцэст буцаан олгохоор өглөгт бүртгэсэнтэй холбоотой.

Тайлант онд 49,4 сая төгрөгийг цэвэр ашигтай ажилласнаас эздийн өмч өссөн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь 2019 онд зорилтот түвшингийн төлөвлөгөөг Батлан хамгаалахын сайдаар батлуулж, үндсэн үйл ажиллагааны орлого 264.5 сая төгрөг, хүүгийн орлого 35.5 сая төгрөг нийт 300.0 сая төгрөгөөр орлогыг төлөвлөснөөс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 333.4 сая төгрөг, хүүгийн орлого 45.8 сая төгрөг нийт 379.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 25.9 хувиар давуулан биелүүлжээ.

Зорилтот түвшингийн 2019 оны нийт үйл ажиллагааны зардалд 292.5 сая төгрөг төлөвлөснөөс 329.7 сая төгрөгийн зардал гаргаж, 49.4 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл тодорхойлоогүй бөгөөд нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс буцаан төлөгдөхгүй 9.6 сая төгрөгийн өглөгийг орлогод авч залруулав.

Аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаандаа оруулж байх зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын урьдчилж гарсан зардал, өр авлагын үлдэгдлийг нарийвчлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-аар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв гүйцэтгэлийн 11, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 31, бусад 44 мэдээллийг хугацаанд нь оруулж, 58 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 88.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмуудын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт өгч байна. Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх 56 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Хууль хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулинд заасан хугацаанд нь байршуулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг дахин давтахгүй анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	613,624,054.97	841,468,356.52
1.1.2	Дансны авлага	23,777,287.43	18,709,698.77
1.1.6	Бараа материал	40,619,313.50	58,011,944.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	67,040,619.92	146,359,979.92
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	745,061,275.82	1,064,549,980.04
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	56,570,065.37	33,444,569.15
1.2.1	Биет бус хөрөнгө	118,866.86	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	56,688,932.23	33,444,569.15
1.3	Нийт хөрөнгийн дүн	801,750,208.05	1,097,994,549.19
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	305,541,447.10	548,068,647.30
2.1.1.3	Татварын өр	7,085,894.93	6,602,964.92
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	90,540,424.69	95,305,928.69
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	403,167,766.72	649,977,540.91
2.2	Өр төлбөрийн нийт дүн	403,167,766.72	649,977,540.91
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Төрийн өмч	125,043,641.34	125,043,641.34
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	24,496,368.57	24,496,368.57
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	249,042,431.42	298,476,998.37
2.3.11	Эздийн өмчийн дүн	398,582,441.33	448,017,008.28
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	801,750,208.05	1,097,994,549.19

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	340,852,629.00	333,379,610.00
2	Борлуулалтын өртөг	75,193,424.00	66,096,392.00
3	Нийт ашиг	265,659,205.00	267,283,218.00
5	Хүүний орлого	7,707,990.50	45,762,308.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	223,735,084.12	255,231,007.29
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8,518,400.00)	
17	Бусад ашиг алдагдал	(1,500,000.00)	(2,598,500.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	39,613,711.38	55,216,018.83
19	Орлогын татварын зардал	4,963,211.14	5,781,451.88
20	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	34,650,500.24	49,434,566.95

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	955,474,047.68	981,327,943.60
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	264,606,601.00	313,391,806.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	298,836,475.58	157,453,886.29
	Бусад мөнгөн орлого	392,030,971.10	510,482,251.31
1.2	Мөнгөн зарлагын дүн	635,782,187.78	799,245,950.17
	Ажиллагчдад төлсөн	95,658,259.45	103,181,732.09
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,383,886.93	18,416,236.44
	Бараа материал худалдан авахад төлсөн	91,003,954.00	68,171,030.00
	Ашиглалтын зардалд төлсөн	91,469,671.07	61,545,876.50
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,807,110.00	27,425,670.00
	Даатгалын төлбөрт төлсөн	23,647,968.19	17,284,955.48
	Бусад мөнгөн зарлага	296,811,338.14	503,220,449.66
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	319,691,859.90	182,081,993.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	7,707,990.50	45,762,308.12
	Хүлээн авсан хүүний орлого	7,707,990.50	45,762,308.12
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,707,990.50	45,762,308.12
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	327,399,850.40	227,844,301.55
5	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>	<u>286,224,204.57</u>	<u>613,624,054.97</u>
6	<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>	<u>613,624,054.97</u>	<u>841,468,356.52</u>

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	274,450,773.24	423,990,783.15
3	<u>Залруулсан үлдэгдэл</u>	<u>125,043,641.34</u>	<u>24,496,368.57</u>	<u>274,450,773.24</u>	<u>423,990,783.15</u>
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал			34,650,500.24	34,650,500.24
6	Өмчид гарсан өөрчлөлт			(60,058,842.06)	(60,058,842.06)
9	2018 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	249,042,431.42	398,582,441.33
11	<u>Залруулсан үлдэгдэл</u>	<u>125,043,641.34</u>	<u>24,496,368.57</u>	<u>249,042,431.42</u>	<u>398,582,441.33</u>
14	Өмчид гарсан өөрчлөлт			49,434,566.95	49,434,566.95
17	2019 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	125,043,641.34	24,496,368.57	298,476,998.37	448,017,008.28

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019-12-31	Аудитын нэр: БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код: САГ-2020/50/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	БХЯ-ны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх 56 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Э.Мөнхнаран А.Дорж

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.